



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 1,028,000,000.00 (нэг тэрбум хорин найман сая) төгрөгийн балансын үнэ, 913,777,777.76 (есөн зуун арван гурван сая долоон зуун далан долоон мянга долоон зуун далан долоон төгрөг далан зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг төрийн өмчит хуулийн этгээдүүдэд балансаас балансад шилжүүлсүгэй.

2."Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаран, холбогдох байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д оруулан бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001505

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн
64 дүгээр тогтоолын хавсралт

**"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын балансаас төрийн өмчит байгууллагуудад
шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

Д/д	Автомашин марк, улсын зугар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/а шиглалтанд орсон он	Тоо шир хэг	нийт гүйлт	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)	Хүлээн авах байгууллага
1	Hyundai Super aerocity 5669 ДГО, автобус КМЈТG18ВРВC007285	2010/2010	1	35147	128,500,000.00	114,222,222.22	14,277,777.78	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК
2	Hyundai Super aerocity 5670 ДГО, автобус КМЈТG18ВРВC009576	2010/2011	1	33573	128,500,000.00	114,222,222.22	14,277,777.78	"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК
3	Hyundai Super aerocity 5671 ДГО, автобус КМЈТG18ВРВC009372	2010/2012	1	38562	128,500,000.00	114,222,222.22	14,277,777.78	"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК
4	Hyundai Super aerocity 5672 ДГО, автобус КМЈТG18ВРВC007283	2010/2013	1	34930	128,500,000.00	114,222,222.22	14,277,777.78	"Биокомбинат" ТӨҮГ
5	Hyundai Super aerocity 5673 ДГО, автобус КМЈТG18ВРВC009376	2010/2014	1	33620	128,500,000.00	114,222,222.22	14,277,777.78	"Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨҮГ
6	Hyundai Super aerocity 5674 ДГО, автобус КМЈТG18ВРВC009575	2010/2015	1	36580	128,500,000.00	114,222,222.22	14,277,777.78	"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК
7	Hyundai Super aerocity 5675 ДГО, автобус КМЈТG18ВРВC009573	2010/2016	1	32889	128,500,000.00	114,222,222.22	14,277,777.78	"Архангай-А33А" ТӨХК
8	Hyundai Super aerocity 5676 ДГО, автобус КМЈТG18ВРВC009375	2010/2017	1	31753	128,500,000.00	114,222,222.22	14,277,777.78	"Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК
			8		1,028,000,000.00	913,777,777.76	114,222,222.24	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		8 (найм)		1,028,000,000.00 (нэг тэрбум хорин найман сая)	913,777,777.76 (есөн зуун арван гурван сая долоон зуун далан долоон мянга хоёр зуун далан зургаан мөнгө)	114,222,222.24 (нэг зуун арван дөрвөн сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг хорин дөрвөн мөнгө)	